

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, зохион байгуулахтай холбоотой оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомж

2.1.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийг нийтэд нээлттэй болгохтой холбогдсон харилцаанд хамаарна.

#### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“бичил уурхай эрхлэгч” гэж ашигт малтмал ашиглах зорилгоор зохион байгуулагдсан Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөл, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршоог;

4.1.2.“мэдээллийн сан” гэж эрдэс баялгийн салбарын цогц үйл ажиллагааны мэдээллийг агуулсан мэдээллийн цахим санг,

4.1.3.“мэдээллийн санд мэдээлэл оруулах үүрэг бүхий этгээд” гэж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан сум, дүүрэг, энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10, 15.1.11, 15.1.12-д заасан байгууллага, хуулийн этгээд, хувь хүнийг;

4.1.4.“өмчлөлийн бүтцийн зураглал” гэж хуулийн этгээдийн өмчлөлийн хэлхээ холбоог дүрсжүүлэн харуулсан, хуулийн этгээдийг шууд болон шууд бус байдлаар удирдан чиглүүлэх эрх бүхий, ашиг хүртэгч, хувьцаа эзэмшигч этгээдийн бүтэн нэр, хуулийн этгээдийн хэлбэр, харьяалагдах улс, эзэмшлийн хувь болон шийдвэрт нөлөөлөх хэлбэр, холбогдох бүртгэлийн дугаарыг харуулсан зураглалыг;

4.1.5.“тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.12, 4.1.13, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан этгээд, Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг;

4.1.6.“төсөл” гэж нэг тусгай зөвшөөрөл, эсхүл нэг буюу хамаарал бүхий хэд хэдэн багц гэрээ хэлэлцээр, эсхүл нэг техник-эдийн засгийн үндэслэлийн хүрээнд хэрэгждэг, эдгээр нь тухайн хуулийн этгээдийн төртэй хийх төлбөр, тооцооны үндсийг бүрдүүлж буй үйл ажиллагааг;

4.1.7.“улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д заасан болон эрх бүхий байгууллагаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаар баталсан этгээдийг;

4.1.8.“хүндэтгэн үзэх шалтгаан” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.41-д заасан нөхцөл байдлыг;

4.1.9.“эрдэс баялгийн салбар” гэж ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх болон бичил уурхайгаар ашигт малтмал ашиглахтай холбоотой цогц үйл ажиллагааг;

4.1.10.“эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан” гэж энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллага, 10 дугаар зүйлд заасан төрийн захиргааны байгууллага, 11 дүгээр зүйлд заасан аймаг, нийслэл, 14 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргах баримт бичгийг;

4.1.11.“эцсийн эзэмшигч” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.48-д заасныг ойлгоно.

## **5 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын зарчим**

5.1. Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөхийн зэрэгцээ дор дурдсан зарчмыг баримтална:

- 5.1.1. ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;
- 5.1.2. оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;
- 5.1.3. эрх тэгш, шударга өрсөлдөөнийг дэмжих;
- 5.1.4. мэдээлэл нь үнэн зөв, бодит, тогтмол шинэчлэгддэг байх;
- 5.1.5. ёс зүйг сахих.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ , ҮҮРЭГ**

### **6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Улсын Их Хурал эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Засгийн газраас хүргүүлсэн эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах.

### **7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1. Засгийн газар эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.2. Үндэсний зөвлөлийн бүтцийг батлах, бүрэлдэхүүнийг томилох;

7.1.3. Үндэсний зөвлөлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг сонгон шалгаруулах журам батлах;

7.1.4. Үндэсний зөвлөлийн ажиллах журам батлах;

7.1.5. мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах журам батлах;

7.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эцсийн эзэмшигч, түүний улс төрд нөлөө бүхий этгээдтэй хамаарал бүхий байдлыг тодорхойлох, ил тод болгох журам батлах;

7.1.7. эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх.

### **8 дугаар зүйл. Төрийн байгууллагын нийтлэг эрх хэмжээ**

8.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан төрийн байгууллага, 15.1.2-д заасан аймаг, нийслэл, 15.1.4-т заасан Засгийн газрын тусгай сан нь дор дурдсан нийтлэг эрх хэмжээтэй байна:

8.1.1.энэ хуульд заасан эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайланг гаргах, шаардлагатай тайлбар, тодруулгыг өгөх;

8.1.2.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр, олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлж, тогтмол шинэчлэх;

## **9 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

9.1.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргыг Засгийн газарт санал болгох;

9.1.2.Дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчлэх:

9.1.2.а.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1.а, 17.1.1.б, 17.1.3.в-д заасан мэдээлэл;

9.1.2.б.уурхай хүлээн авах комиссын мэдээлэл.

9.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2.б, 17.1.2.г, 17.1.2.д, 17.1.2.ё, 17.1.2.ж, 17.1.7.а, 17.1.7.б, 17.1.8.а, 17.1.8.б, 17.1.8.в, 17.1.8.д, 17.1.8.е, 17.1.9.е, 17.1.9.ё, 25.2.2-д заасан мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ.

9.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.3.1.нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө, холбогдох тайлангийн ил тод байдлыг хангах журам батлах;

9.3.2.Дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчлэх:

9.3.2.а.байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл тус бүрээр;

9.3.2.б.аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх харьяа байгууллагын нэгдсэн мэдээлэл;

9.3.2.в.ус ашиглах дүгнэлт, гадаргын болон гүний ус ашиглалт, дахин ашигласан усны хэмжээ, ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл тус бүрээр;

9.3.2.г.усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ, сав газрын захиргаанаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан ус ашиглах гэрээ, хэрэгжилтийн мэдээлэл;

9.3.2.д.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8.ё, 17.1.11.а, 17.1.11.б-д заасан мэдээлэл.

9.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ:

9.4.1.эрдэс баялгийн салбарын жендэрийн нарийвчилсан болон нэгтгэсэн мэдээлэл;

9.4.2.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8.з, 17.1.9.ж, 17.1.9.з-д заасан мэдээлэл;

9.5.Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9.а, 17.1.9.б-д заасан мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ.

## **10 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

10.1.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангийн өгөгдлийг төрийн холбогдох байгууллагын мэдээлэлтэй тогтмол тулган баяжуулахад Ажлын албанд дэмжлэг үзүүлэх;

10.1.2.Дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ:

10.1.2.а.тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр, үйлчилгээний хураамж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой орлогыг тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр;

10.1.2.б.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1.в, 17.1.2.в, 17.1.2.е, 17.1.3.а, 17.1.3.б, 17.1.3.г, 17.1.4.а, 17.1.4.б, 17.1.6.а, 17.1.7.а, 17.1.8.б, 17.1.8.г, 17.1.8.д-д заасан мэдээлэл;

10.1.2.в.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2.а-д заасан эрдэс баялгийн салбарын нөөцийн мэдээлэл, 17.1.8.б-д заасан Засгийн газрын ногдох ашигт газрын тос, хувьцааны ногдол ашиг.

10.2.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасан эцсийн эзэмшигчийн мэдээллийн санг бүрдүүлэх, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан, улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай уялдуулах, олон нийтэд ил тод мэдээлэх нээлттэй мэдээллийн санд холбох, тогтмол шинэчлэх ажлыг зохион байгуулах;

10.2.2.улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн мэдээлэлтэй тогтмол хугацаанд тулгалт хийж баталгаажуулах, мэдээллийн зөрүүг холбогдох байгууллагад хүргүүлж, харилцан баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх;

10.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ:

10.3.1.төсөвт төвлөрүүлж буй татварын орлогыг ашигт малтмалын төрөл, тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч, төсөл тус бүрээр;

10.3.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл эцсийн эзэмшигч солигдсон, тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь шилжүүлсэн, худалдан борлуулснаас төсөвт төвлөрсөн татвар, холбогдох мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн бусад сантай уялдуулах.

10.4.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ:

10.4.1.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7.а-д заасан мэдээллийг ашигт малтмалын төрөл, гарал үүсэл, төсөл, тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр;

10.4.2.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7.б-д заасан мэдээлэл.

10.5.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.12-т заасан мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ.

10.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ:

10.6.1.эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэрэгжүүлэх хууль тогтоомж, дагаж мөрдөх бодлого, төлөөлөн удирдах зөвлөл, түүний хороод, гүйцэтгэх удирдлагын гэрээ, гэрээг дүгнэсэн баримт бичиг;

10.6.2.эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хуримтлуулсан ашиг, хөрөнгө оруулалт, ногдол ашиг ба хуваарилалт, гуравдагч талын санхүүжилт, зээлд баримт бичиг;

10.6.3.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5.а, 17.1.5.г, 17.1.9.в, 17.1.9.е, 17.1.9.ё, 17.1.9.й-д заасан мэдээлэл.

10.7. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.7.1.эрдэс баялгийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;

10.7.2.хяналт шалгалтын мэдээлэл, түүнд хамаарах хуулийн этгээдийн бүртгэл, ногдуулсан хариуцлагын талаар нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчлэх.

10.8.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8.з-д заасан мэдээллийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч тус бүрээр гарган, нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ.

10.9.Хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2.з, 17.1.9.ж-д заасан мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл тус бүрээр нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ.

10.10.Стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь эрдэс баялгийн салбарт мөрдөх нээлттэй мэдээллийн стандартыг батална.

## **11 дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүрэг**

11.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, урамшуулал, хандив дэмжлэгийн мэдээллийг нийтэд цахимаар тогтмол мэдээлэх;

11.1.2.дараах гэрээ, түүний хэрэгжилтийг нийтэд цахимаар тогтмол мэдээлнэ:

11.1.2.а.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээ болон нөхөн сэргээлтийн гэрээ;

11.1.2.б.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1.в-д заасан түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой мэдээлэл, 17.1.2.а-д заасан хандив дэмжлэгийн, 17.1.4.д, 17.1.8.д, 17.1.8.ё, 17.1.8.ж, 17.1.10.а, 17.1.10.в-д заасан мэдээлэл;

11.1.2.в.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг дэмжих талаар баталсан хөтөлбөр, түүний хэрэгжилт.

11.2.Сум, дүүргийн Засаг дарга нь дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчилнэ:

11.2.1.хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, хандив дэмжлэгийн мэдээлэл;

11.2.2.дараах гэрээ, түүний хэрэгжилтийн мэдээлэл:

11.2.2.а.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйл, Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17-д заасан гэрээ;

11.2.2.б.газар, ус ашиглах болон нөхөн сэргээлтийн гэрээ;

11.2.2.в.бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах гэрээ.

11.2.3.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2.а-д заасан хандив дэмжлэгийн, 17.1.4.д, 17.1.8.д, 17.1.8.ё, 17.1.8.ж, 17.1.10.а, 17.1.10.в-д заасан мэдээлэл.

11.3.Аймаг, нийслэлийн засаг дарга нь энэ хуульд заасан салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж, батламжлуулахаар Үндэсний зөвлөлд хүргүүлнэ.

*Тайлбар: Сум, дүүрэг нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан гаргахгүй бөгөөд холбогдох мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлд хүргүүлнэ.*

## **12 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын чиг үүрэг**

12.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгчтэй холбоотой гаргасан аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх;

12.1.2.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1.в-д заасан түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тухайн шатны Засаг даргад хүргүүлэх.

## **13 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн чиг үүрэг**

13.1.Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.1.энэ хуульд заасны дагуу эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайланг гаргах, шаардлагатай тайлбар, тодруулгаар хангах;

13.1.2.дараах мэдээллийг нийтэд цахимаар мэдээлж, тогтмол шинэчлэх:

13.1.2.а.санхүү, техникийн нөөц, хүний нөөцийн төлөвлөгөө;



13.1.2.б.төсвийн зарцуулалтын тайлан, тухайн зарцуулалттай холбоотой төрийн өмчит компанийн хамаарал бүхий компанийн өмчлөлийн бүтцийн зураглалыг, тайлбарын хамт;

13.1.2.в.санхүүгийн аудитын тайлан;

13.1.2.г.ханган нийлүүлэлт, засаглал, урамшуулал, үйл ажиллагааны бодлого, журам, зардал, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, ёс зүйн дүрэм журам;

13.1.2.д.зээл, зээлийн баталгаа, үнэт цаас гаргах шийдвэр, хэмжээ, нөхцөл, эргэн төлөх хуваарь.

13.1.2.е.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5.г, 17.1.7.а, 17.1.8.е, 17.1.9.а, 17.1.9.в-д ханган нийлүүлэлтийн мэдээлэл, 17.1.9.г, 17.1.9.е, 17.1.9.ё-д заасан мэдээлэл.

*Тайлбар: “хамаарал бүхий” гэж Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг ойлгоно.*

#### **14 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгчийн эрх, үүрэг**

14.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч нь дор дурдсан нийтлэг эрх, үүрэгтэй байна:

14.1.1.энэ хуульд заасны дагуу эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайланг гаргах, шаардлагатай тайлбар, тодруулгыг өгөх;

14.1.2.Үндэсний зөвлөл, түүний ажлын албанаас шаардсан тодруулгын хариуг ажлын 10 хоногт багтаан үнэн зөв гаргах, шаардлагатай мэдээллийг хамаарал бүхий нэгж, салбар, толгой, охин компаниар гаргуулах;

14.1.3.энэ хуульд заасан эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой сургалт, мэргэжил арга зүйн туслалцаа, тодруулга, мэдээллийг үнэ төлбөргүй авах;

14.1.4.мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаажуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

14.1.5.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх;

14.1.6.мэдээллийн санд мэдээллээ гаргахаар бүртгүүлэх эрх бүхий албан тушаалтан нь бүрэн гүйцэд, үнэн зөв бичиг баримттай байх;

14.1.7.энэ хуульд эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайланг гаргахдаа компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтан, этгээдээр баталгаажуулах;

14.1.8.газрын тос, ашигт малтмал тээвэрлэлтийн гэрээ, тээвэрлэлтэд оролцож буй этгээдийг нийтэд мэдээлэх;

14.1.9.тээвэрлэлтийн тариф, түүнийг тооцох аргачлал;

14.1.10.тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эцсийн эзэмшигч, хамаарал бүхий компанийг өмчлөлийн бүтцийн зураглал, тайлбарын хамт нийтэд цахимаар мэдээлэх;

14.1.11.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11.в-д заасан мэдээллийг нийтэд цахимаар мэдээлэх.

14.1.12.хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуульд заасан хугацаанд тухайн жилийн тайлан гаргах боломжгүй болсон бол энэ тухай Үндэсний зөвлөлд мэдэгдэж, шийдвэрлүүлэх.

*Тайлбар: энэ хэсгийн 14.1.8-д заасан мэдээллийг гаргахдаа гадаад улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн газрын тос, ашигт малтмал тээвэрлэлтийн гэрээг түүнтэй гэрээ байгуулсан дотоодын аж ахуйн нэгж тайлагнана.*

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭРДЭС БАЯЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

### **15 дугаар зүйл.Эрдэс баялгийн мэдээллийн санг бүрдүүлэх үүрэг**

15.1.Дараах төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүн эрдэс баялгийн мэдээллийн санг бүрдүүлэх үүрэгтэй:

15.1.1.энэ хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага;

15.1.2.энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан аймаг, сум, нийслэл, дүүрэг;

15.1.3.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

15.1.4.Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.8, 5.3.15-д заасан тусгай сан, эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулах төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлсэн орлогоос бүрдүүлсэн бусад сан;

15.1.5.эрдэс баялгийн салбарт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч;

15.1.6.энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч;

15.1.7.энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшлийн хувийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээд;

15.1.8.ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, эрэл, ашиглалтын үйл ажиллагаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар төрийн байгууллагад хүсэлт гаргасан хуулийн этгээд;

15.1.9.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийлбэр дүнгээр тухайн санхүүгийн жилд гарсан үйл ажиллагааны зардлын тав ба түүнээс дээш хувьтай тэнцэх үнийн дүн бүхий нэг ба түүнээс дээш тооны хамтран ажиллах гэрээ байгуулсан эсхүл адил хэмжээний үнэ бүхий бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээ байгуулсан хуулийн этгээд;

15.1.10.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс тухайн санхүүгийн жилийн борлуулалтын орлогын тав ба түүнээс дээш хувьтай нь тэнцэх үнийн дүн бүхий бараа, бүтээгдэхүүн, эд хөрөнгө, үйлчилгээг худалдаж авсан хуулийн этгээд;

15.1.11.бичил уурхай эрхлэгч;

15.1.12.энэ хэсгийн 15.1.5, 15.1.6, 15.1.7, 15.1.9, 15.1.10, 15.1.11-д заасан этгээдэд хувьцаа болон бусад хэлбэрээр хөрөнгө оруулагч, удирдлага, хяналт хэрэгжүүлэх хэлбэрээр шийдвэр гаргагч.

*Тайлбар: энэ хэсгийн 15.1.12 дахь заалт нь зохицуулагч байгууллагад бүртгэлтэй, нээлттэй компанид хамаарахгүй.*

## **16 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сан**

16.1.Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд нээлттэй мэдээллийн стандартад нийцсэн байна.

16.2.Мэдээллийн сангийн мэдээлэл нь тоон мэдээлэл, өгөгдөл, дуу авиа, дүрс бичлэг, зураг, график, бичгийн хэлбэртэй байна. Кадастрын зурган мэдээлэл нь Засгийн газраас тодорхойлсон солбицол, өндрийн тогтолцоонд, өмчлөлийн бүтцийн зураглал нь батлагдсан маягтад нийцсэн байна.

16.3.Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, эрх бүхий этгээд баталгаажуулах ажлыг цахимаар гүйцэтгэнэ.

16.4.Ажлын алба нь энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан этгээдийн мэдээлэл, бүртгэлийг цахим хэлбэрт оруулсныг нягтлах, шалгах, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, баталгаажуулах, мэдээллийн сангийн байнгын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хариуцан, мэдээллийн сангийн уялдаа холбоо, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангаж ажиллана.

16.5.Мэдээллийн сан нь төрийн хамгаалалтад байна.

16.6.Мэдээллийн сангийн мэдээлэл нь холбогдох хуульд зааснаас бусад тохиолдолд олон нийтэд нээлттэй байна.

## **17 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл**

17.1.Мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

### **17.1.1.төрийн бодлого зохицуулалт, түүнтэй холбоотой мэдээлэл:**

17.1.1.а.эрдэс баялгийн салбарт баримтлах төрийн бодлого, шинэчлэл, хууль тогтоомж, холбогдох төрийн байгууллагын чиг үүрэг, өөрчлөлт;

17.1.1.б.эрдэс баялгийн салбарт эцсийн эзэмшигчийн мэдээллийг бүрдүүлэх талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, хэрэгжилтийн мэдээлэл;

17.1.1.в.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, хуулийн этгээдэд тавигдах техникийн болон санхүүгийн шалгуур, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, цуцлахтай холбогдолтой зохицуулалт, хэрэгжилтийн мэдээлэл.

### **17.1.2.эрдэс баялгийн салбарын орлого, зарлага, төсөвтэй холбоотой мэдээлэл:**

17.1.2.а.эрдэс баялгийн салбарын нөөц боломж, орлого, зардал, татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, урамшуулал, хандив дэмжлэгийн мэдээлэл;

17.1.2.б.эрдэс баялгийн салбараас бүрдүүлсэн төсвийн бус орлогын эх үүсвэрийн ангилал;

17.1.2.в.эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэл, төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл;

17.1.2.г.эрдэс баялгийн салбарын эдийн засагт үзүүлэх үр өгөөж, таамаглал, тооцоолол;

17.1.2.д.төсвийн бодлого, эрдэс баялгийн салбараас төвлөрөх орлого, төсвийн хуваарилалт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн төсөвт шилжүүлсэн дүн, тооцох аргачлал;

17.1.2.е.газрын кадастрын мэдээлэл, талбайн солбицол, түүнийг тодорхойлох журам, холбогдох шийдвэр, тайлбар, өөрчлөлтийн мэдээлэл;

17.1.2.ё.үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого;

*Тайлбар: энэ заалтын 17.1.2.ё-д заасан “борлуулах хэлбэр” гэж мөнгөн хэлбэр эсхүл своп гэрээ, нөөцөөр баталгаажсан зээл зэрэг борлуулах нөхцөлийг тодорхойлохыг хэлнэ.*

17.1.2.ж.газрын тос болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн хүлээн авсан орлого;

17.1.2.з.гадаад ажиллах хүчний ажлын байрны төлбөр.

**17.1.3.тусгай зөвшөөрлийн бүртгэлийн мэдээлэл:**

17.1.3.а.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлийн, сонгон шалгаруулалтын үр дүн, сонгон шалгаруулалтад оролцсон хуулийн этгээдийн жагсаалт;

17.1.3.б.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын олгосон, шилжүүлсэн, түдгэлзүүлсэн, цуцалсан, маргаантай тусгай зөвшөөрлийн мэдээлэл, төрөл, ашиглалтын тусгай зөвшөөрөлд холбогдох бүтээгдэхүүний төрөл;

17.1.3.в.үйлдвэрлэл, технологийн паркын үйл ажиллагааны олгосон, шилжүүлсэн, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, цуцалсан, маргаантай тусгай зөвшөөрлийн мэдээлэл, паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл;

17.1.3.г.тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх, цуцлахтай холбоотой хууль тогтоомжийн зөрчил, маргааны мэдээлэл.

**17.1.4.гэрээний мэдээлэл:**

17.1.4.а.энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;

17.1.4.б.энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан байгууллагын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бичил уурхай эрхлэгчтэй байгуулсан гэрээ;

17.1.4.в.газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ, төлөвлөгөө;

17.1.4.г.түрээсэлсэн, барьцаалсан тусгай зөвшөөрөлд холбогдох гэрээ, арилжааны зээлийн нөхцөлтэй харьцуулсан харьцуулалт;

17.1.4.д.Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагааны тэмдэглэл, гэрээний дагалдах хуудас.

**17.1.5.эцсийн эзэмшигчийн мэдээлэл:**

17.1.5.а.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаа эзэмшигч болон эцсийн эзэмшигчийн дэлгэрэнгүй мэдээлэл;

17.1.5.б.эцсийн эзэмшигч нь улс төрд нөлөө бүхий этгээд эсэх мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдэд тооцогдож эхэлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

17.1.5.в.хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглал ба тайлбар, төрийн эзэмшил дэх хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаасны хувь хэмжээ;

17.1.5.г.Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын дэлгэрэнгүй мэдээлэл, төлөөлж буй байгууллага, төлөөллийн эзэмшлийн хувь хэмжээ, албан тушаал, томилогдсон шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлд ажилласан жил, цалин урамшуулал, улс төрийн намын гишүүнчлэлийн байдал.

#### **17.1.6. хайгуул, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн мэдээлэл:**

17.1.6.а.тухайн жилийн хайгуул, баяжуулах болон боловсруулах үйлдвэрлэлийн мэдээлэл, борлуулалт, экспортын тоо хэмжээ, өөрийн өртөг, зардал, экспортын дундаж үнэ, тооцооллын эх сурвалж болон аргачлалын мэдээлэл.

#### **17.1.7.экспортын мэдээлэл:**

17.1.7.а.экспортын төлөвлөгөө, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ, нэгж үнэ, борлуулалтын хэлбэр, хүлээн авсан орлого, худалдан авагчийн нэр, харьяалал;

17.1.7.б.ашигт малтмал, бүтээгдэхүүн экспортлогч болон хүлээн авагч улс, хуулийн этгээдийн мэдээлэл.

#### **17.1.8.татвар, төлбөр, хураамж:**

17.1.8.а.эрдэс баялгийн салбарын татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээ, орлого, тусгай зориулалтын сангийн орлогыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл тус бүрээр, хуваарилалт;

17.1.8.б.Засгийн газарт ногдох ашигт газрын тосны хэмжээ, төлбөр, хувьцааны ногдол ашиг, бусад томоохон хэмжээний орлого болон материаллаг үр шим, төрийн өмчит хуулийн этгээд хооронд болон бусад төрийн байгууллага хооронд хийгдсэн буй төлбөр;

17.1.8.в.нөөц ашигласны төлбөр;

17.1.8.г.гарын үсгийн, хайгуулын ажлын, үйлдвэрлэлийн болон бусад төлбөр, урамшуулал, дэмжлэг, үйлчилгээний хөлсний мэдээлэл;

17.1.8.д.тусгай зөвшөөрлийн төлбөр;

17.1.8.е.төлбөр, бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн арилжааны журмаар ханган нийлүүлэх, зээл, тусламж олгох, дэд бүтэц барих зэрэг үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ, хэлэлцээрийн дагуу хийгдсэн төлбөр, орлого;

17.1.8.ё.байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дүн;

17.1.8.ж.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн хөрөнгө оруулалтын мэдээлэл;

17.1.8.з.нийгмийн даатгалын шимтгэлийн дүн болон ажиллах хүчний тоо.

**17.1.9.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

17.1.9.а.бүтээгдэхүүн, түүхий эд тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэсэн бүтээгдэхүүн, тоо хэмжээ, тээвэрлэсний орлого, тээвэрлэгч этгээдийн мэдээлэл;

17.1.9.б.тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, хураамж болон тэдгээрийг тооцох аргачлал, тайлбар;

17.1.9.в.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт, ханган нийлүүлэлтийн сонгон шалгаруулах нөхцөл, ханган нийлүүлэлтийн гэрээ, хэрэгжилтийн мэдээлэл;

17.1.9.г.төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэнд өгсөн хандив, тусламжийн хэмжээ, хэлбэр, зориулалт;

17.1.9.д.эд хөрөнгийн болон эрхийн барьцааны талаарх мэдээлэл;

17.1.9.е.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гуравдагч этгээдээс авсан зээл, зээлийн баталгаа, батлан даалтын мэдээлэл, улсын төсвөөс авсан хөнгөлөлт, татаас;

17.1.9.ё.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон Засгийн газрын санхүүгийн харилцааны талаарх мэдээлэл;

17.1.9.ж.эрдэс баялгийн салбарт гадаад болон Монгол Улсын ажиллах хүч, нийт ажиллагчдын тоонд гадаад ажилтны эзлэх хувь, ажиллах байршил, холбогдох зөвшөөрөл, орон нутгийн иргэдийн ажлын байрны мэдээлэл, хүйс, боловсрол, албан тушаал;

17.1.9.з.эрдэс баялгийн салбарын нийгмийн стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, төслийн нийгмийн нөлөөллийн төлөв байдал болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, холбогдох менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан, дагалдах бичиг баримт, тайлан гаргасан болон боловсруулсан хуулийн этгээдийн жагсаалт;

17.1.9.и.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гэрээ дүгнэсэн баримт бичиг, хяналтын хуудас;

17.1.9.й.төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх шийдвэр, контракт, дүгнэлт, төрийн өмчийг захиран зарцуулахад олгогдсон эрх.

*Тайлбар:энэ заалтын 17.1.9.ё-д заасан “санхүүгийн харилцаа” гэж төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн*

этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрын хооронд хийгдсэн мөнгөн болон мөнгөн бус шилжүүлэг, холбогдох шийдвэрийг ойлгоно.

#### **17.1.10.орон нутгийн төлбөр, нийгмийн хариуцлага, хандив дэмжлэг:**

17.1.10.а.тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгчээс өгсөн хандив, тусламжийн хэмжээ, хэлбэр, зориулалт;

17.1.10.б.төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэнээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн;

17.1.10.в.орон нутгийн гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээлэл.

#### **17.1.11.байгаль орчин, нөхөн сэргээлтийн мэдээлэл**

17.1.11.а.нөхөн сэргээлт хийх болон химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах тусгай зөвшөөрлийн жагсаалт, олгосон, сунгасан, дуусгавар болох огноо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэл;

17.1.11.б.эвдэрсэн, нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ, нөхөн сэргээлтийн ангилал, байршил, тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч тус бүрээр;

17.1.11.в.төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд авсан дээж, шинжилгээний дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээний мэдээлэл;

17.1.11.г.байгаль орчны хяналт шалгалтын дүн, дүгнэлт, зөвлөмж, хэрэгжилтийн мэдээлэл, байгаль орчны аудитын гүйцэтгэгдсэн талаарх мэдээлэл;

17.1.11.д.ундны болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны зөвшөөрөгдсөн ба хэрэглэсэн хэмжээ, дахин ашигласан ус, байгаль орчны нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээлэл;

#### **17.1.12.газрын мэдээлэл:**

17.1.12.а.газрын нэгдмэл сангийн кадастрын зураглал, аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөө, суурьшлын бүс, өвөлжөө, хаваржааны байршил, газар эзэмших, ашиглах зөвшөөрөл, эзэмшигч хуулийн этгээдийн жагсаалт, байршил, ашиглах, эзэмших гэрээний мэдээлэл.

17.2. Үндэсний зөвлөлийн шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

### **18 дугаар зүйл. Мэдээллийн хадгалалт, хамгаалалт**

18.1.Мэдээллийн сангийн мэдээлэл нь хорин жилээс доошгүй хугацаанд хадгалагдаж, олон нийтэд ил тод, нээлттэй байна.

18.2.Мэдээллийн сангийн мэдээллийг хууль бусаар ашиглахыг хориглоно.



18.3.Холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүн нь мэдээллийг ил тод болгохгүй байх хүсэлтийг гаргаж болох бөгөөд тухайн хүсэлтийг холбогдох хуулийн дагуу Үндэсний зөвлөл шийдвэрлэнэ.

18.4.Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д заасан мэдээллийг тодорхой хугацаанд нууцлах тохиолдолд тухайн этгээд мэдээллийн санд тайлан, мэдээлэл гаргах үүргээс чөлөөлөгдөхгүй.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА САНХҮҮЖИЛТ, ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН**

#### **19 дүгээр зүйл. Үндэсний зөвлөл**

19.1.Эрдэс баялгийн салбарт ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг төр, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий Үндэсний зөвлөл хангаж ажиллана.

19.2.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд геологи, уул уурхай, санхүү, төсөв, хууль зүй, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Авлигатай тэмцэх газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг жендэрийн тэгш байдлыг хангаж оролцуулна.

19.3.Үндэсний зөвлөл нь дараах чиг үүрэг бүхий бие даасан Ажлын албатай байна.

19.3.1.энэ хуульд заасан эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайланг хүлээн авах,

19.3.2. энэ хуульд заасан эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланг боловсруулах,

19.3.3.мэдээлэлд дүн шинжилгээ хийх,

19.3.4.эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах санал, зөвлөмж боловсруулах,

19.3.5.Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

19.4.Үндэсний зөвлөл нь Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратегийг баталж, үйл ажиллагааны төсвийн саналыг энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

19.5.Үндэсний зөвлөлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулж, 3 жилийн хугацаагаар томилно.

19.6.Үндэсний зөвлөл нь төр, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллагын тэнцүү төлөөллөөс бүрдсэн эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбар зөвлөлийг байгуулж болно.

19.7.Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөл томилно.

19.8.Салбар зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.

## **20 дугаар зүйл.Үндэсний зөвлөлийн чиг үүрэг**

20.1.Үндэсний зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланг хэлэлцэж, олон нийтэд мэдээлэх, Засгийн газарт хүргүүлэх;

20.1.2.эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хувь хүн, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, хоорондын зохистой харилцаа, хамтын ажиллагааг дэмжих;

20.1.3.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайлангийн зөвлөмжийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах;

20.1.4.эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сурталчлах, ил тод байдлын талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;

20.1.5.эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан гаргахтай холбоотой мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, тодруулга өгөх, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;

20.1.6.эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой санал боловсруулж, төрийн холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;

20.1.7.Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, тайлан нэгтгэгчийн үйл ажиллагаа болон эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах;

20.1.8.энэ хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа тайлан гаргагч тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагыг олон нийтэд сурталчлах;

20.1.9.эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, маягт, зөвлөмж батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

20.1.10.салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн захиргааны нэгжийн Засаг дарга томилж, Үндэсний зөвлөл батламжилна.

20.2.Энэ хуулийн 14 дүгээр 14.1.7-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий этгээд эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайланг баталгаажуулаагүй бол Ажлын алба хүлээн авахаас татгалзах эрхтэй.

20.3.Үндэсний зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагаанд хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно.

20.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуульд заасан хугацаанд тухайн жилийн тайлан гаргах боломжгүй болсон тухай Үндэсний зөвлөлд мэдэгдсэн бол Үндэсний зөвлөл тайлан гаргах хугацааг хойшлуулж болно.

## **21 дүгээр зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан**

21.1.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан нь дор дурдсан төрөлтэй байна:

- 21.1.1.төрийн байгууллагын тайлан;
- 21.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан;
- 21.1.3.нэгдсэн тайлан.

21.2.Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2-д заасан тайлангийн маягыг Үндэсний зөвлөлийн санал болгосноор шалатистикийн хороо батална.

## **22 дугаар зүйл.Төрийн байгууллагын ил тод байдлын тайлан**

22.1.Төрийн байгууллагын тайланг энэ хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага гаргана.

22.2.Энэ хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага өрийн байгууллага нь тухайн жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор гаргаж, мэдээллийн санд оруулна.

22.3.Төрийн байгууллага нь ил тод байдлын тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн төрийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн гаргана.

## **23 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын тайлан**

23.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор гаргаж, мэдээллийн санд оруулна.

23.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь аудиталсан санхүүгийн тайланд үндэслэн тайлагнана.

## **24 дүгээр зүйл.Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлын тайлан**

24.1.Эрдэс баялгийн салбарт ил тод байдал, сайн засаглалыг хангах, авлига болон ашиг, сонирхлын зөрчлийг бууруулах чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн холбоо,

олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцож болно.

24.2.Үндэсний зөвлөлийн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан гаргах бөгөөд дор дурдсан мэдээллийг тусгана:

24.2.1.үүсгэн байгуулагч, удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын дэлгэрэнгүй мэдээлэл;

24.2.2.санхүүжилтийн мэдээлэл;

24.2.3.үйл ажиллагааны чиглэл, эрдэс баялгийн салбарын ил тод байдал, засаглалын чиглэлээр өмнөх жилүүдэд хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ;

24.2.4.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх үүрэг бүхий этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлийн мэдээлэл.

24.3.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тайлан гаргаагүй иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлнө.

24.4.Үндэсний зөвлөлийн иргэний нийгмийн төлөөлөл нь эрдэс баялгийн салбарт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хүлээн авсан хандив, дэмжлэг, гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний тайланг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээллийн санд оруулна.

## **25 дүгээр зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайлан**

25.1.Үндэсний зөвлөл нь энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3-д заасан эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланг дараа оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэн олон нийтэд мэдээлж, Засгийн газарт хүргүүлнэ.

25.2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланд энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан тайлангийн төлбөр, орлогын дүнгийн тэнцлээс гадна дор дурдсан мэдээллийг тусгана:

25.2.1.улсын эдийн засагт эрдэс баялгийн салбарын эзлэх хувь хэмжээ;

25.2.2.эрдэс баялгийн салбарын нийт орлого, тэдгээрийн дотор төсвийн орлогын дүн, төсвийн орлогын хуваарилалт, төсвийн орлогын тогтвортой байдлын тухай;

25.2.3.олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний төрөл, хэмжээг тусгай зөвшөөрөл, төсөл тус бүрээр;

25.2.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төр, төрийн бус байгууллагад өгсөн хандив дэмжлэгийн хэмжээ, хэлбэр;

25.2.5.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон төрийн байгууллагын ил тод байдлын тайлан хоорондын зөрүү, түүний тайлбар, тодруулга;

25.2.6.ил тод байдлын тайлан ирүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч болон төрийн байгууллагын талаарх мэдээлэл;

25.2.7.эрдэс баялгийн салбарын ил тод байдал, засаглалыг сайжруулах талаархи дүгнэлт, зөвлөмж, өмнөх тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт.

25.3.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланд өгсөн иргэний нийгмийн нийт байгууллагын дүгнэлтийг Үндэсний зөвлөлд танилцуулна.

## **26 дугаар зүйл.Ил тод байдлын тайлангийн зөрүүг хянан шийдвэрлэх**

26.1.Ажлын алба нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланд тусгасан мэдээллийн зөрүүг тодруулах хүсэлтийг холбогдох тайлан гаргасан үүрэг бүхий этгээдэд хүргүүлж болно.

26.2.Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан этгээд ажлын 5 хоногийн дотор холбогдох нэмэлт мэдээлэл, тайлбарыг Ажлын албанд хүргүүлнэ.

26.3.Ажлын алба нь энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д заасан мэдээлэл, тайлбарыг хүлээн авсны дараа зөрүүг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн этгээд шаардлагатай тохиолдолд зөрүү үүсгэж байгаа мэдээлэлтэй танилцаж болно.

26.4.Ажлын алба нь тайлангийн зөрүүг шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл энэ талаар тайлбар, зөвлөмжийг эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланд тусгах бөгөөд энэ талаар тайлан гаргах үүрэг бүхий этгээдэд мэдэгдэнэ.

26.5.Үндэсний зөвлөл нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайланд тусгагдсан зөрүүг хэрхэн шийдвэрлэж болох талаарх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ.

## **27 дугаар зүйл.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт**

27.1.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

27.2. Ажлын алба нь Үндэсний зөвлөл, түүний бүтцийн байгууллагын үйл ажиллагааны жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу бэлтгэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч уг төсвийн төслийг багцдаа тусган зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

27.3.Салбар зөвлөлийн төсвийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

27.4.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилт нь бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд хүрэлцээтэй байна.

27.5.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан хувь хүн, хуулийн этгээд, байгууллагаас зээл, хандив, тусламж авахыг хориглоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **28 дугаар зүйл.Гомдол хянан шийдвэрлэх**

28.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан этгээд нь эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл холбогдох хуулийн дагуу гомдол гаргах эрхтэй:

28.1.1.Ажлын алба, салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Үндэсний зөвлөлд;

28.1.2.Үндэсний зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдох гомдлыг Засгийн газарт.

28.2.Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

### **29 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

29.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.3.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

30.1.Энэ хуулийг 2021 оны .... сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

ГАРЫН ҮСЭГ